



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан



Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгосон ч хууль, журамд заасан шаардлага хангаагүй 6 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна.

АГУУЛГА

Тайлан бэлтгэсэн:	АГУУЛГА	3
Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь	ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	6
Аудитын менежер М.Бат-Амгалан	ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	7
Ахлах аудитор Б.Авирмэд	АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ	8
Аудитор Р.Аюуш Л.Шагдарсүрэн	БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДАЖ БАЙГАА Ч ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ЗАРИМ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.	10
	<i>1.1 Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй хоёр төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.</i>	10
	1.1.1 “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгаагдаагүй эрх шилжиж ирсэн 2 төсөл, арга хэмжээ байна.	10
2026 оны 4 дүгээр сар	1.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн төлөвлөсөн байна.	13
	1.1.3 Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн 575.0 сая төгрөгийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.	15
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317 дугаарын утсаар харилцана уу.	1.1.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцоож эрэмбэлэх зохицуулалт нь Төрийн захиргааны төв байгууллагад байна.	16
	<i>1.2 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.</i>	16
Хаяг: Увс аймаг дахь Төрийн аудитын газар Улаангом сум 3 дугаар баг, аймгийн Засаг даргын тамгын газрын байр	1.2.1 Тайлант хугацаанд эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.	16
	1.2.2 Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, үнийн судалгаа, тооцоололд үндэслэн ТЭЗҮ, цахим систем, тоног төхөөрөмжийн өртгийг төлөвлөөгүй байна.	18
	1.2.3 Шинээр хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан төлөвлөөгүй байна.	19
	1.2.4 Шилжих 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дутуу төлөвлөж, хуваарилсан байна.	20

1.2.5 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж төлөвлөсөн байна.	21
БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.	22
2.1 Эрх шилжин хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.	22
2.1.1 Захиалагч худалдан авалтын төлөвлөгөөг батлах, багцад хуваарилах, үнэлгээний хороо байгуулах шийдвэрийг хугацаанд гаргасан ч 1 төсөл арга хэмжээг эрх шилжүүлэхдээ хуульд заасан хугацааг зөрчсөн байна.	22
2.1.2 Захиалагч техникийн тодорхойлолт, магадлалын дүгнэлтийг боловсруулж худалдан авах ажиллагааг зохион байгуулах нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна.	23
2.1.3 Төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж зарласан байна.	23
2.1.4 Эрх шилжсэн нэг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.	24
2.1.5 Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.	24
2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.	25
2.2.1 Худалдан авах ажиллагаанд оролцогчид Сангийн яаманд тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй байна.	25
2.2.2 Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй тул хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх үндэслэл үүсээгүй байна.	25
2.2.3 Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл, мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээг орон нутагт хийдэггүй байна.	25
БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА.	27
3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн байна.	27
3.1.1 Зарим төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна.	27
3.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.	28

3.1.3 Төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн ч 1 төсөл арга хэмжээний зориулалтыг өөрчилж, 1 төсөл арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангагдаагүй байна.	29
3.1.4 Тайлант онд эрх шилжүүлсэн 8 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэсэн байна.	34
3.2 Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.	34
3.2.1 Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, акт фото зургаар баталгаажуулсан байна.	34
3.2.2 Барилга байгууламжийн бетоны бат бэхэд хяналт хэрэгжүүлсэн байна.	36
3.2.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан байна.	37
3.2.4 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг байршуулсан байна.	38
3.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлж бүртгэсэн ч 1 төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.	38
3.3.1 Хэрэгжиж дууссан 4 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл, арга хэмжээг зориулалтаар нь ашиглаж эхлээгүй байна.	38
3.3.2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан журам заасны дагуу бүрэн тайлагнаагүй байна.	40
3.3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлснээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.	41
3.3.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж 84.3%-ийн биелэлттэй байна.	43
ДҮГНЭЛТ	44
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	45
АУДИТЫН ГАЗРААС ӨГӨХ ТАЙЛБАР	49
ЗӨВЛӨМЖ	50

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ

УВА	УВС АЙМАГ
ШТА	ШУУД ТАЙЛАГНАХ АУДИТ
НА	НИЙЦЛИЙН АУДИТ
ТЭЗҮ	ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ
АДБОУС	АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ
АХ	АЛСЫН ХАРАА
МУХТЖҮЧ	МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ
ЗГҮАХ	ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
АЗДҮАМХ	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР
УТХО	УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ
УИХ	УЛСЫН ИХ ХУРАЛ
ТБОНӨХБАҮХАТ	ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ
ГХБХБГ	ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР
ЦХХХЯ	ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛАЛ	
Хүснэгт-1	Бодлогын баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээний уялдаа
Хүснэгт-2	Бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилт
Хүснэгт-3	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд Pimis системээр хүргүүлсэн санал
Хүснэгт-4	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээнд хүргүүлсэн санал
Хүснэгт-5	Зураг төсөв, магадлалын дүгнэлттэй төсөл арга хэмжээний мэдээлэл
Хүснэгт-6	Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар хийгдсэн төсөл арга хэмжээний мэдээлэл
Хүснэгт-7	Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ
Хүснэгт-8	Эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөлт, хуваарилалт
Хүснэгт-9	Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээ
Хүснэгт-10	Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа
Хүснэгт-11	Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн
Хүснэгт-12	Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлт, гүйцэтгэлийн хувь
Хүснэгт-13	Он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 4 төсөл, арга хэмжээ
Хүснэгт-14	Бетоны бат бөхийн лабораторийн дүгнэлт
Хүснэгт-15	Байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээ
Хүснэгт-16	Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээллийн самбар байршуулсан байдал
Хүснэгт-17	Эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хөрөнгийн бүртгэл
Хүснэгт-18	Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт
Хүснэгт-19	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/179 дүгээр тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2026 онд гүйцэтгэх аудитын жилийн төлөвлөгөө, Увс аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийлээ.

Аудитын зорилт

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

Хамарсан хүрээ

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан эрх шилжсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга, ЗДТГ-ын холбогдох хэлтсүүд, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглав.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг нэгдсэн удирдамжаар хийсэн бөгөөд Увс аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь хянан удирдаж, аудитын менежер М.Бат-Амгалан аудитын стандартыг хангуулан, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Авирмэд, аудитор Р.Аюуш, Л.Шагдарсүрэн нар хийж гүйцэтгэлээ.

Ерөнхий зүйл

Увс аймагт 2025 оны төсвийн тухай хуулиар 108,243.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2025 онд санхүүжих дүн нь 36,805.7 сая төгрөг байна.

Түүнчлэн 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдсан сайд нарын багцаас 16,625.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүн нь 8,311.0 сая төгрөг байна.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР, ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ УЯЛДАЖ БАЙГАА Ч ХУУЛЬ, ЖУРАМД ЗААСАН ЗАРИМ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

1.1 Хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй 2 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.1.1 “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй эрх шилжиж ирсэн 2 төсөл, арга хэмжээ байна.

Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана”, 27.1.8 дахь заалтад “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх”, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бэлтгэнэ”, 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2} дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29^{1.2.5} дахь заалтад “Тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх”, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1-д заасан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно”, 5.2.12 дахь заалтад “Төлөвлөлтийн дээрээс доош, доороос дээш чиглэх тэнцвэрийг хангах зарчим” гэж “дээрээс доош” төлөвлөх буюу нэгдсэн зорилго, зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх, “доороос дээш” төлөвлөх буюу төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын төсөл хөтөлбөрүүдийн саналыг нэгтгэн, нэгдмэл зорилго, зорилтыг тодорхойлж төлөвлөхийг”, 5.2.17 дахь заалтад ““Төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчим” гэж энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3, 6.10.4-т заасан шаардлагыг хангаж Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулахыг”, 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт “Нэг жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг нь дараах шаардлагыг хангасан байна”, 6.10.1 дэх хэсэгт “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан байх”, 6.10.3 дахь заалтад “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж тус тус заасан байна.

Увс аймагт Монгол улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд хийгдэхээр 124,869.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 29 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2025 онд олгох санхүүжилт нь 45,116.7 сая төгрөг байна.

Төсвийн тухай хуулиар батлагдсан 29 төсөл, арга хэмжээний хувьд Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030

онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны дараах зорилтуудад нийцсэн ажлууд байна. Тухайлбал:

- ❖ Зорилт 2.2. Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ.
- ❖ Зорилт 9.2. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.
- ❖ Зорилт 2.1. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ.
- ❖ Зорилт 2.6. Хөдөлмөрийн эдийн засгийн тэнцвэрийг хангаж, мэдлэгийн эдийн засгийг бүрдүүлж, иргэн бүрийг ажилтай, орлоготой болгоно.
- ❖ Зорилт 3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.
- ❖ Зорилт 6.3. Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ.
- ❖ Зорилт 8.1. Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.
- ❖ Зорилт 8.2. Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- ❖ Зорилт 9.2. Иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.
- ❖ Зорилт 9.3. Орон зайн оновчтой төлөвлөлт бүхий суурьшлын зөв тогтолцоотой, эрчимтэй хөгжиж байгаа дагуул хотуудтай олон улсад өрсөлдөгч метрополитан болж хөгжинө.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор баталсан Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Увс аймагт эрх шилжин хэрэгжиж буй 8 төсөл, арга хэмжээг “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан эсэхийг тулгаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 1. Бодлогын баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээний уялдаа

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөтэй уялдсан эсэх	Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй уялдсан эсэх	Бодлогын үндэслэл
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 1 /Увс Наранбулаг сум/	Тийм	Тийм	АХ-8.2 МУХТЖҮЧ-9.5.5, ЗГҮАХ-3.3.2.10
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 2 /Увс Цагаанхайрхан сум/	Тийм	Тийм	АХ-8.2 МУХТЖҮЧ-9.5.5, ЗГҮАХ-3.3.2.10
XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	Үгүй	Үгүй	АХ-6.3 МУХТЖҮЧ-6.3.4, ЗГҮАХ-3.3.4.22

XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	Тийм	Тийм	АХ-2.1 МУХТЖҮЧ-2.1.1, 2.1.8, ЗГҮАХ-2.2.1.4
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	Үгүй	Үгүй	АХ-9.3 МУХТЖҮЧ-8.1.3, ЗГҮАХ-3.3.2.2
XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	Тийм	Тийм	АХ-8.1 МУХТЖҮЧ-7.5.2, ЗГҮАХ-4.3.2.2
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	Тийм	Үгүй	АХ-9.5 МУХТЖҮЧ-4.2.8, ЗГҮАХ-2.4.3.4
XII.1.3.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	Тийм	Үгүй	АХ-9.1 МУХТЖҮЧ-2.1.10, ЗГҮАХ-2.1.1.10

Эх сурвалж: “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”

Дээрх хүснэгтээс харахад эрх шилжин хэрэгжиж буй 8 төсөл, арга хэмжээ “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол улсын “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан байна.

Харин “Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдаагүй 2 төсөл, арга хэмжээ байна. Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3 дахь заалтад “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг баталж байх зөвлөмж чиглэл өгч ажиллах талаар ҮАГ-ын нэгтгэсэн тайланд тусгуулах санал хүргүүлж байна.

Эрх шилжиж хэрэгжиж буй 8 төсөл, арга хэмжээ нь аймгийн “Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”, “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгагдсан эсэхийг тулгаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Бодлогын баримт бичигт тусгасан зорилго, зорилт

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	“Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-тэй уялдсан эсэх	“Аймгийн Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдсан эсэх	“Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгасан эсэх
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц1 /Увс Наранбулаг сум/	Зорилт 8.2	АЗДҮАМХ-3.3.3	Тийм

XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 2 /Увс Цагаанхайрхан сум/	Зорилт 8.2	АЗДҮАМХ-3.3.3	Тийм
XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	Зорилт 6.3	АЗДҮАМХ-3.1.3	Тийм
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	Зорилт 2.1	АЗДҮАМХ-2.1.1	Тийм
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	Зорилт 8.1	АЗДҮАМХ-3.6.1	Тийм
XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	Зорилт 8.1	АЗДҮАМХ-3.6.4	Тийм
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	Зорилт 8.1	АЗДҮАМХ-1.2.3	Үгүй
XII.1.3.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	Зорилт 2.1	АЗДҮАМХ-2.1.1	Үгүй

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

Дээрх хүснэгтээс харахад эрх шилжин хэрэгжиж буй 8 төсөл, арга хэмжээ “Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”, “Увс аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Харин “Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгагдаагүй 2 төсөл, арга хэмжээ байна. Эдгээр 2 төсөл, арга хэмжээ нь “Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө” батлагдсаны дараа 2026 онд сайдын багцаас эрх шилжиж ирсэнтэй холбоотойгоор тусгагдаагүй байна.

1.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.4-т заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ”, 6.5.5 дахь заалтад “Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх”, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэгт “Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана”, 27.1.1 дэх заалтад “Төсвийн зарчмыг мөрдлөг болгох”, 29¹ дүгээр зүйлийн 29^{1.1} дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч **эрэмбэлсэн**, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна” гэж заажээ.

Засгийн газрын 2023 оны 278 дугаар тушаалаар баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 2.3-д "Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ", 2.3.1-т "Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар", 2.3.1.1-д "Тухайн орон нутагт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг холбогдох хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэх, эрэмбэлэх", 2.3.1.2-д "Тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг төсвийн төсөлд тусгуулахаар тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасан байна.

Аймгийн Засаг дарга нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал хүргүүлэхдээ сумдын болон багийн Иргэдийн нийтийн хурлын саналыг авч аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан эрэмбэлж төлөвлөсөн байна.

Увс аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 1/1251 дүгээр албан бичгээр Увс аймагт Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр 775,691.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 70 төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, ТЭЗҮ, зураг төслийн саналыг холбогдох газруудад хүргүүлсэн байна.

Хүснэгт 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд Pimis системээр хүргүүлсэн санал

Д/д	Яамны нэр	Төсөл арга хэмжээний саналын тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
1	Шадар сайд	1	1,003.6
2	Хууль зүй дотоод хэргийн яам	6	7,837.5
3	Барилга хот байгуулалтын яам	10	82,949.4
4	Эрчим хүчний яам	7	26,519.3
5	Зам тээвэр хөгжлийн яам	7	507,000.5
6	Эрүүл мэндийн яам	8	18,526.0
7	Боловсрол шинжлэх ухааны яам	12	80,128.3
8	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	4	6,628.3
9	Байгаль орчин аялал жуулчлалын яам	4	1,012.4
10	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	2	300.0
11	Соёл, спорт аялал жуулчлалын яам	3	7,178.9
12	Монгол улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга	2	3,253.4
13	Монгол улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга	4	33,354.2
Нийт		70	775,691.8

Эх сурвалж: Увс аймгийн Засаг даргын 2025 оны албан бичиг

Дээрх шинээр хэрэгжүүлэхээр хүргүүлсэн төсөл, арга хэмжээний саналыг Pimis системээр төлөвлөж, төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулж үнэлсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 1/1323 дугаар албан бичгээр "Ерөнхий боловсролын 3, 4 дүгээр сургуулийн мэдээллийн технологийн танхимыг шинэчлэх ажил - 300.0 сая төгрөг"-ийн саналыг Боловсролын

яаманд, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 1/2152 дугаар албан бичгээр “Хилийн цэргийн 0311 дүгээр ангийн 0212, 0320 дугаар салбарыг цахилгаан эрчим хүчинд холбох”, 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 1/2081 дүгээр албан бичгээр “Хилийн цэргийн 0245 дугаар ангийн 0228, 0308 дугаар салбарыг цахилгаан эрчим хүчээр хангах” хүсэлтийг Эрчим хүчний яаманд тус тус хүргүүлсэн байна.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, төсөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын удирдлагыг хариуцан ажиллах бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 2.1.1-д “Төсөл, арга хэмжээний саналыг энэ журамд зааснаар хүлээн авах, боловсруулах, нэгтгэх, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналт, тайлагналтын удирдлагыг хэрэгжүүлэх”, 2.1.2-д “Төсөл, арга хэмжээний төсвийн эрсдэлийн үнэлгээг хийх, тухайн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргах”, 2.1.3-д “Төсөл, арга хэмжээг холбогдох журам, аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах санал боловсруулах” гэж заасан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн жагсаалтад Увс аймгийн Засаг даргын хүргүүлсэн 70 төсөл, арга хэмжээний саналаас 5 саналыг дэмжиж, 13,179.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ, тоног, төхөөрөмж, барилга, байгууламжийг баталсан байна. Үүнд:

- Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/ -4,498.9 сая
- Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/ Багц-20: 4,580.4 сая
- Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/ Багц-21: 1,851.3 сая
- Бүс нутгийн найдвартай цахилгаан хангамж, 1 дүгээр үе шат /Бүсүүд/ Багц-22: 2,098.5 сая
- “Ерөнхий боловсролын сургуульд Цахим танхим”-ын тоног төхөөрөмж /Увс аймаг/ худалдан авах-150.0 сая

1.1.3 Дараа онд хэрэгжүүлэх ажлын бэлтгэл хангахад чиглэсэн 575.0 сая төгрөгийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Увс аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 1/1251 дүгээр албан бичгээр Увс аймагт Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр 2,580.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 ТЭЗҮ, зураг төслийн саналыг хүргүүлсэн байна.

Мөн аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 1/42 дугаар албан бичгээр “Улаангом сумын 5, 6-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын зураг, төсөл боловсруулах-400.0 сая”, 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 1/43 дугаар албан бичгээр “Улаангом сумын 6, 7, 9, 10, 12-р багийн гэр хорооллын инженерийн шугам сүлжээний 1-р хэлхээний шугам, эх үүсвэрийн зураг, төсөл боловсруулах-1,500.0 сая”, 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 1/44 дүгээр албан бичгээр “Улаангом сумын ус хангамжийн болон дулааны төв магистрал шугам, 2-р хэлхээний шугамыг өргөтгөх, зарим УДДТөвийн хүчин чадлыг нэмэгдүүлэх-800.0 сая”, Улаангом сумын Ерөнхий боловсролын 2 дугаар

“Сургуулийн спорт заалны барилгын зураг төсөв”, 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 1/39 дүгээр албан бичгээр “Улаангом сумын төвийн тохижилтын ажлын зураг, төсөл боловсруулах-200.0 сая төгрөг” саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлсэн байна.

Хүснэгт 4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах төсөл, арга хэмжээнд хүргүүлсэн санал

Д/д	Яамны нэр	Төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн саналын тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
1	Хууль зүй дотоод хэргийн яам	1	100.0
2	Барилга хот байгуулалтын яам	2	1,100.0
3	Эрчим хүчний яам	3	900.0
4	Эрүүл мэндийн яам	1	50.0
6	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам	1	400.0
8	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд	1	30.0
11	Эдийн засгийн хөгжлийн яам	5	2,954.0
Нийт		14	5,534.0

Эх сурвалж: Увс аймгийн Засаг даргын 2025 оны албан бичиг

"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын дагуу Увс аймгийн Засаг даргын хүргүүлсэн 14 ТЭЗҮ, зураг, төслийн саналаас 460.0 сая төгрөгийн 2 саналыг дэмжиж, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Бүсүүд/, 26.Увс аймгийн Улаангом сум доторх инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ТЭЗҮ, зураг төсөв – 406.0 сая
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээ /Бүсүүд/ Ерөнхий боловсролын сургуулийн (28х15) спорт заалны өргөтгөлийн зураг төсөв /Увс аймаг/ -54.0 сая

1.1.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож эрэмбэлэх зохицуулалт нь Төрийн захиргааны төв байгууллагад байна.

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.1} дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, 29^{1.3} дахь заалтад “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний урьдчилсан үнэлгээг хийж төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын зээл, тусламж зэрэг санхүүжилтийн эх үүсвэрийг эрэмбэлэн тогтооно” гэж заасны дагуу Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож эрэмбэлэх зохицуулалттай байна.

1.2 Төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.2.1 Тайлант хугацаанд эрх шилжин хэрэгжсэн 6 төсөл, арга хэмжээ төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.1} дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, 29^{1.2} дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх” гэж заажээ. Үүнд:

- ❖ 29^{1.2.1} дэх заалтад “тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”
- ❖ 29^{1.2.2} дахь заалтад “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг, төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”
- ❖ 29^{1.2.3} дахь заалтад “техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх”
- ❖ 29^{1.2.4} дэх заалтад “Урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх”
- ❖ 29^{1.2.5} дахь заалтад “Тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх”
- ❖ 29^{1.2.6} дахь заалтад “Олон нийтээр хэлэлцүүлсэн байх”

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжиж буй 8 төсөл, арга хэмжээнээс зураг төсөв, магадлалын дүгнэлт шаардлагатай 6 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 5. Зураг төсөв, магадлалын дүгнэлттэй төсөл арга хэмжээний мэдээлэл

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Төсөвт өртөг (сая.төгрөг)	Магадлалын дүгнэлт (огноо, дугаар)
1	XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 1 /Увс Наранбулаг сум/	2024	796.0	2024.10.10 №1841/2024
2	XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 2 /Увс Цагаанхайрхан сум/	2024	400.3	2024.10.10 №1840/2024
3	XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	3,473.8	2024.07.26 №1273/2024
4	XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	2024	4,668.7	2024.06.07 №218/2024
5	XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	2024	900.0	Цамхаг 2024.08.30 №1593/2024 Байр 2024.01.22 №0091/2024
6	XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	2025	4,498.9	2025.04.08 № 59/2025, 2025.06.17 №968/2025

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх судалгаанаас харахад Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Засгийн газар барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 32.1.11 дэх заалтад “Зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3 дахь заалтад “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам”-ын 5.5-д “Энэ журмын 5.4-т заасны дагуу ирүүлэх төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, газар нь чөлөөлөгдсөн, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх шаардлагатай бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөлд сонгох үнэлгээг хийхгүй” гэж заасан байхад Тухайн оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг батлагдсаны дараа магадлалын дүгнэлтийг гаргасан 2024 оноос он дамжин хэрэгжүүлсэн 5, тайлант онд шинээр хэрэгжсэн 1 төсөл, арга хэмжээг Улсын Их Хурлаар баталсан нь хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Энэ нь тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөвт өртөг нэмэгдэх, зориулалт өөрчлөгдөх зэрэг сөрөг үр дагаврууд гарах эрсдэл үүсгэж байна.

Тухайлбал: 2024 оноос он дамжин хэрэгжиж буй “Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/” анх жишиг зураг ашиглан 3,473.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй баталж гэрээ байгуулан ажилласан байна.

Гэтэл жишиг зурагт суурийн холболтын зураг хийлгэж Барилгын хөгжлийн төвийн 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 1273/2024 дугаар магадлалын дүгнэлтээр нийт төсөвт өртөг 4,189.0 сая болж, 715.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Иймд дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулах санал хүргүүлж байна.

Эрх шилжин хэрэгжиж буй 6 төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлт нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29¹.2.2 дахь заалтад “Барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх” гэж заасантай нийцэж байна.

1.2.2 Ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, үнийн судалгаа, тооцоололд үндэслэн ТЭЗҮ, цахим систем, тоног төхөөрөмжийн өртгийг төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, 29¹.2 дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх”, 29¹.2.3 дахь заалтад “Техник эдийн

засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх” гэж заасан байхад тайланд онд эрх шилжин шинээр хэрэгжиж буй 1 төсөл, арга хэмжээ хуульд заасан шаардлагыг хангаагүй байна.

Хүснэгт 6. Техникийн тодорхойлолт, ажлын даалгавраар хийгдсэн төсөл, арга хэмжээний мэдээлэл

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг ((сая.төг)	Техникийн тодорхойлолт (Ажлын даалгаврын огноо)
1	XII.1.3.1	Ерөнхий боловсролын сургуульд Цахим танхим-ын тоног төхөөрөмж /Увс аймаг/ худалдан авах	2025	2026	150.0	ТЭЗҮ 2025.08.21

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Энэ нь тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд төсөвт өртөг нэмэгдэх, эдийн засгийн үр өгөөж алдагдах зэрэг сөрөг үр дагаврууд гарах эрсдэл үүсгэж байна.

Иймд дээрх хуулийн заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

1.2.3 Шинээр хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдуулан төлөвлөөгүй байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтад “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.3.4.2-т “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төслийн нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах” гэсэн шаардлагыг хангаагүй шинээр баталсан эрх шилжин хэрэгжиж буй 1 төсөл, арга хэмжээг 2025 оны төсвийн тухай хуульд тусгасан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг (сая.төгрөг)	2025 онд санхүүжих дүн	Хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилбал зохих дүн (сая.төг)	Зөрүү (Хувь)
1	XVI.1.1	Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/	2025	2027	4,498.9	1,117.8	1,499.6	8.5%

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх судалгаанаас “Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/” төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс бага байгаа нь хууль журмын шаардлагатай нийцэхгүй байна.

Иймд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

1.2.4 Шилжих 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дутуу төлөвлөж, хуваарилсан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтад “Шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож, гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах”, 29.3.6 дахь заалт “Тухайн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүнг төсвийн тодотголоор бууруулахгүй байх” гэж заасан байна.

Эрх шилжин он дамжин хэрэгжиж байгаа 10,483.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүн нь 4,797.8 сая төгрөг байна.

Хүснэгт 8. Эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөлт, хуваарилалт

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хэрэгжих хугацаанд тэнцүү хуваарилбал зохих дүн (сая.төг)	Зөрүү /хувь/
1	XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц ¹ /Увс Наранбулаг сум/	2024	2026	796.0	246.5	265.3	- 2.4%
2	XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 2 /Увс Цагаанхайрхан сум/	2024	2026	400.3	349.8	133.4	54%
3	XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг, төсөв /Увс, Өндөрхангай сум/	2024	2026	245.0	95.0	81.7	5.4%
4	XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	2024	2026	3,473.8	2,258.0	1,157.9	31.7%
5	XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	2024	2026	4,668.7	1,533.5	1,556.2	-0.5%
6	XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	2024	2026	900.0	315.0	300.0	1.7%
Дүн					10,483.8	4,797.8	3,494.6	

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Дээрх судалгаанаас харахад 5,019.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтыг хангаж,

5,464.7 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгийн тухайн жилд ногдох хэсэг нь төслийг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс 0.5-2.4 хувиар дутуу хуваарилсан байна.

Иймд Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах талаар Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулахаар санал хүргүүлж байна.

1.2.5 Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.4-т “санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 8.4.3-т заасан жилийн төсвийн саналыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцүүлэн нэгтгэн боловсруулж, эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулж, жил бүрийн 08 дугаар сарын 15-ны дотор Засгийн газарт өргөн мэдүүлж, нийтэд ил тод мэдээлэх”, 10 дугаар зүйлийн 10.1-т “Засгийн газар төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 10.1.3-д “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх”, 9 дүгээр зүйлийн 9.1-т “Улсын Их Хурал төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 9.1.2-т “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлж улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улсын төсөв, Ирээдүйн өв сангийн төсөв, Үндэсний баялгийн сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, тэдгээрийн тодотголыг хэлэлцэж, батлах” гэж заасны дагуу Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөг УИХ-ын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолоор баталсан байна.

Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралт, Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай УИХ-ын 35 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүдийг хэмжигдэхүйц байдлаар тодорхойлсон байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

2.1 Эрх шилжин хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээнээс 1 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

2.1.1 Захиалагч худалдан авалтын төлөвлөгөөг батлах, багцад хуваарилах, үнэлгээний хороо байгуулах шийдвэрийг хугацаанд гаргасан ч 1 төсөл, арга хэмжээг эрх шилжүүлэхдээ хуульд заасан хугацааг зөрчсөн байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт "Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ" гэж заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Tender.gov.mn дээр байршуулсан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсэгт "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах", 13.1.2. дэх хэсэгт "Энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох" гэж заасныг зөрчиж Боловсролын сайдын 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/411 дүгээр тушаалаар "Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж" /Увс аймаг/ худалдан авах төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн байна. Тус асуудлыг нэгтгэл тайланд тусгуулахаар Үндэсний аудитын газарт санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 25 дугаар тушаалаар "инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/" төсөл арга хэмжээний эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 48 дугаар зүйлд "Захиалагчийн эрх, үүрэг", 48.2.2 дэх хэсэгт "Үнэлгээний хороо байгуулах" гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн "Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/" төсөл, арга хэмжээнд аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/187 дугаартай захирамжаар үнэлгээний хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй, "Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/" төсөл, арга хэмжээнд аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/460 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороог хуульд заасан хугацаанд буюу тендер зарлагдахаас өмнө байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.4, 50.5, 50.6 дахь хэсэгт заасны дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд төрийн бус байгууллагын төлөөлөл, Засаг даргын Тамгын газрын ажилтан, тухайн бараа, ажил, үйлчилгээнд холбогдох салбарт мэргэшсэн хүнийг томилон ажиллуулсан байна.

Төсөл сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 1 гишүүн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 5 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийн дагуу ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж худалдан авах ажиллагаанд оролцохоос татгалзсан байна.

2.1.2 Захиалагч техникийн тодорхойлолт, магадлалын дүгнэлтийг боловсруулж худалдан авах ажиллагааг зохион байгуулах нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана” гэж заасны дагуу “Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/” төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Засаг дарга баталж, Худалдан авах ажиллагааны газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.

“Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/” төсөл, арга хэмжээний нэршлийг өөрчилж “Увс аймагт ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэлтийн ажлын зураг төсөл, Наадмын талбайн авто зогсоол”-ын зураг төсвийг “Засмал зам” ХХК, “Ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэлт”-ийн зураг төсвийг Итгэлийн хад ХХК боловсруулан магадлалын дүгнэлтээр баталгаажуулж аймгийн Худалдан авах ажиллагааны газарт хугацаанд нь хүргүүлсэн байна.

2.1.3 Төсөл, арга хэмжээний онцлог, цар хүрээнд тулгуурлан оролцогчдод тавигдах шаардлагыг тендерийн баримт бичигт тусгаж зарласан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална”, 11.2 дахь хэсэгт “Оролцогчийг тендер бэлтгэж ирүүлэхэд шаардагдах мэдээлэл, оролцогчид тавих шаардлага, заавар, хамгийн сайн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, тендерийн жишиг маягтыг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана” гэж заасны дагуу тендерийн баримт бичгийг боловсруулжээ.

Хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэгт “Барилга байгууламж, дэд бүтэцтэй холбогдох техникийн тодорхойлолтод хуульд заасан тохирох хэрэглэгдэхүүн, түгээмэл загварыг тусгана” гэж заасны дагуу “Увс аймгийн Улаангом суманд хэрэгжих “Инженерийн шугам сүлжээний ажил”-ын худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа тухайн ажлын онцлог, гүйцэтгэх цар хүрээ, техникийн нөхцөлүүдийг үндэслэн зураг төсвийг “Засмал зам” ХХК, “Итгэлийн хад” ХХК боловсруулж магадлалын дүгнэлтээр баталгаажуулж тендерийн баримт бичигт хавсаргасан байна.

“Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахдаа холбогдох заавар, журмыг баримталсан бөгөөд аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр баталсан техникийн тодорхойлолтын дагуу тоног төхөөрөмжийн үзүүлэлт, хүчин чадал болон нийлүүлэгчид тавигдах шаардлагуудыг төслийн цар хүрээнд нь нийцүүлэн тендерийн баримт бичигт тусгаж зарласан байна.

2.1.4 Эрх шилжсэн нэг төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх хэсэгт “Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах” гэж заасныг зөрчиж “Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/” төсөл, арга хэмжээний тендерийг 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдөр эрх шилжиж ирснээс шалтгаалан 08 дугаар сарын 22-ны өдөр зарласан байна.

Харин “Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/” арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулсан байна.

Хүснэгт 9. Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	Худалдан авалтын арга	Төсөвт өртөг сая.төг	Гэрээ байгуулсан дүн сая.төг
1	Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/	Нээлттэй	4,498.9	4,498.9
2	“Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/”	Нээлттэй	150.0	149.8

Эх сурвалж: Худалдан авах ажиллагааны баримт

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэг “Нээлттэй тендер шалгаруулалтын тендер хүлээн авах эцсийн хугацаа ажлын 15-аас дээш, энэ хуулийн 8.3-т заасан тендер шалгаруулалтад ажлын 20-оос дээш өдөр байхаар заана” гэж заасныг мөрдөж ажилласан байна.

Хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.6 дахь хэсэгт “Худалдан авах гэрээ байгуулах” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох тухай” 1/1541 дүгээр албан бичгийн дагуу “Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/ худалдан авах” БЯ/20250102056 дугаартай бараа худалдан авах тендерийн гэрээг Мобинет ХХК-тай, аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн “Гэрээ байгуулах эрх олгох тухай” 1/786 дугаар албан бичгийн дагуу “Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/” ХББОСЯ/20250101006 УТ2502923326004 дугаартай гэрээг Мөнхжим Өргөө” ХХК-тай тус тус байгуулсан байна.

2.1.5 Тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага хангасан оролцогчийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол оролцогчийг ерөнхий шаардлага хангаагүй гэж үзнэ”, 15 дугаар зүйлд “Чадавхын болон туршлагын шаардлага тавих үндэслэл”, 16 дугаар зүйлд “Санхүүгийн чадавхын шаардлага” гэж заасны дагуу тендер шалгаруулалтын үнэлгээний явцад оролцогчдоос ирүүлсэн тендерийг тендерийн баримт бичигт заасан санхүүгийн чадавх, техникийн тодорхойлолт болон туршлагын шаардлагуудыг үнэлсэн байна.

“Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом/” төсөл, арга хэмжээний хувьд барилга угсралтын ажлын онцлог, магадлалын ерөнхий дүгнэлтэд тулгуурлан тендерийн баримт бичигт заасан техникийн чадавх, тусгай зөвшөөрөл, ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага болон санхүүгийн чадвар зэрэг тавигдах

шаардлагыг хангасан “Мөнхжим өргөө” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулсан байна.

“Цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/” төсөл, арга хэмжээний хувьд аймгийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдөр баталсан техникийн тодорхойлолтод заасан стандарт, үзүүлэлт бүхий барааг нийлүүлэхээр санал болгож, тендерийн баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг хангасан “Мобинет” ХХК-ийг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон байна.

2.2 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

2.2.1 Худалдан авах ажиллагаанд оролцогчид Сангийн яаманд тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй байна.

ТБОНӨХБАҮХАТ тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дэх хэсэгт “Энэ хуулийн 30.2-т заасан үндэслэлээр гэрээ байгуулах доод хугацааг мөрдөлгүй гэрээ байгуулсан захиалагчийн шийдвэрийг мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор гомдол гаргах оролцогчийн эрхийг хязгаарлахгүй” гэж заасны дагуу Захиалагч тендерт шалгарсан хуулийн этгээдтэй 6-аас дээш хоногийн дараа гэрээ байгуулсан байна.

Эрх шилжсэн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах явцад тендерт оролцогчдын зүгээс тендерийн баримт бичиг болон үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой аливаа гомдол, саналыг эрх бүхий байгууллагад гаргаагүй бөгөөд хуулийн 58 дугаар зүйлд “Өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад гомдол гаргах”, 59 зүйлд “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх” гэж заасны дагуу оролцогчдод гомдол гаргах, эрх ашгаа хамгаалах хуулийн хугацааг бүрэн олгосон байна.

2.2.2 Тендер шалгаруулалттай холбоотой гомдол гараагүй тул хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх үндэслэл үүсээгүй байна.

Тайлант хугацаанд эрх шилжсэн 2 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны бүхий л үе шатанд оролцогчдын зүгээс тендерийн баримт бичиг, үнэлгээний үйл ажиллагаа болон шийдвэрлэлттэй холбоотой аливаа маргаан, гомдол гаргаагүй байна. Сангийн яам болон өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой ямар нэгэн гомдол гараагүй тул хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдэх үндэслэл үүсээгүй байна.

2.2.3 Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн бүртгэл, мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээг орон нутагт хийдэггүй байна.

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.5 дахь хэсэгт “Цахим системийн ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар сургалт зохион байгуулах” гэж заасны дагуу Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны АЗ сертификат олгох шалгалтыг 2025 онд 3 удаа зохион байгуулж нийт 149 хүн хамрагдсан байна.

Хуулийн 49.4 дэх хэсэгт “Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 49.4.1 дэх хэсэгт “Цахим системийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлаар захиалагч,

оролцогчийг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах”, 49.4.5 дахь хэсэгт “цахим системийн ашиглалт, худалдан авах ажиллагааны талаар сургалт зохион байгуулах” гэж заасны дагуу 19 сумын албан хаагчдад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын гол өөрчлөлт, холбогдох журам, шинэчлэн гарсан маягтуудыг танилцуулж, user.tender.gov.mn цахим системийн ашиглалт, тендерийн баримт бичиг боловсруулалт, хянан үзэх шатны үйл ажиллагааны талаарх зөвлөгөө зөвлөмжийг өгч ажилласан байна.

Хуулийн 22 дугаар зүйлийн 22.10 дахь хэсэгт “Оролцогч цахим системээр тендер илгээхэд үйлчилгээний хураамж төлнө”, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/248 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.3.8-д “Цахим системээр тендер илгээхэд үйлчилгээний хураамж төлөх” гэж заасны дагуу тендерт оролцогч бүр цахим системээр тендер илгээхдээ үйлчилгээний хураамж төлж байна. Тайлант хугацаанд 108 аж ахуй нэгж худалдан авах ажиллагаанд оролцож 5.4 сая төгрөгийн хураамжийг Төрийн Худалдан авах ажиллагааны газрын дансанд байршуулснаас 70 хувь буюу 3.8 сая төгрөгийг Орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.

Төрийн худалдан авах ажиллагааны газар нь хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 22.10-т заасан хураамжийн 30 хүртэл хувийг цахим системийн найдвартай ажиллагаа, шинэчлэл сайжруулалт, аюулгүй байдлыг хангахад зарцуулах” гэж заасны дагуу зарцуулсан байна.

Хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт “Худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д зааснаас гадна худалдан авах ажиллагааг зохион байгуулах талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 49.4.9 дэх заалтад “цахим системийн ашиглалтад дүн шинжилгээ хийж, холбогдох мэдээ, тоо баримтыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага худалдан авах ажиллагааны талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хяналт тавих чиглэлээр дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 55.1.6 дахь заалтад “худалдан авах ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, журам, заавар, аргачлалын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх” гэж заасан тул хяналт шинжилгээ үнэлгээг төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр байна.

**БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АЖЛЫН
ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА.**

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь санхүүжүүлж, гүйцэтгүүлсэн байна.

3.1.1 Зарим төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд хэрэгжүүлээгүй байна.

Увс аймагт 2025 оны төсвийн тухай хуулиар 108,243.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 2025 онд санхүүжих дүн нь 36,805.7 сая төгрөг байна.

Түүнчлэн 2025 оны төсвийн тухай хуульд тусгагдаж, сайд нарын багцаас 16,625.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба 2025 онд санхүүжих дүн нь 8,311.0 сая төгрөг байна.

Үүнээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн 6, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багцаас эрх шилжүүлсэн 1, Боловсролын сайдын багцаас эрх шилжүүлсэн 1, нийт 8 төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт 10 Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хэрэгжих хугацаа

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Гэрээний эхлэх огноо	Дуусах огноо	Сунгасан огноо
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг	796.0	246.5	12/10/2024	8/25/2025	7/30/2026
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан	400.3	349.8	11/11/2024	10/20/2025	4/30/2026
XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	245.0	95.0	5/24/2024	8/30/2025	6/1/2026
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	3,473.8	2,258.0	10/15/2024	8/30/2025	8/14/2026
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	4,668.7	1,533.5	6/27/2024	11/30/2025	12/30/2026
XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	900.0	315.0	5/10/2024	3/30/2025	11/30/2026
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	4,498.9	1,117.8	5/16/2025	7/21/2027	
XII.1.3.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	150.0	150.0	9/30/2025	11/14/2025	

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/, Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/ төсөл, арга хэмжээг хуулийн болон гэрээний хугацаа дуусахаас өмнө хэрэгжүүлэн комисст хүлээлгэн өгсөн байна.

Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан хугацаандаа бүрэн хэрэгжсэн ч үлдэгдэл санхүүжилт 2026 оны төсөвт тавигдсанаас шалтгаалж гэрээг сунгасан байна.

Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/ төсөл арга хэмжээг гүйцэтгэгч бүрэн хэрэгжүүлсэн боловч Сагил сумын станцын газрын зөвшөөрөл гараагүйгээс шалтгаалж комисс ажиллаагүй байна.

Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/-ийг гэрээний хугацаанаас 42 хоног хоцорсон ч тухайн онд нь хүлээлгэн өгсөн байна.

Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/, Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/ төсөл, арга хэмжээнүүд нь он дамжин 2026 онд хэрэгжиж дуусахаар 2025 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан бана.

Харин Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг арга хэмжээний хувьд худалдан авах ажиллагааг 9 сард зарласнаас шалтгаалж 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан тул ажил эхлэх хугацаа хойшилж төсвийн тодотголд орсноос хэрэгжих хугацааг хойшлуулж гэрээний хугацааг сунгасан байна.

3.1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 11. Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүн

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2025 онд Санхүүжих дүн	2025 онд олгосон санхүүжилт	Нийт олгосон санхүүжилт
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг	796.0	246.5	246.5	246.5
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан	400.3	349.8	349.8	349.8
XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	245.0	95.0	95.0	145.0
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	3,473.8	2,258.0	2258.0	2258.0
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	4,668.7	1,533.5	1533.5	3133.5
XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	900.0	315.0	0.0	270.0
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	4,498.9	1,117.8	1117.8	1117.8
XII.1.3.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	150.0	150.0	0.0	0.0

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсэгт “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.6 дахь

заалтад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заажээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн эрх шилжиж ирсэн 8 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэйгээр хүлээн авсан ч санхүүжилтийг бүрэн олгоогүй байна. Үүнд:

- Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан
- Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/
- Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/
- Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/

Бусад 4 төсөл, арга хэмжээний хувьд он дамжин хэрэгжихээр гэрээний хугацааг сунгасан ба эрх бүхий байгууллагаас хянаж баталгаажуулсан гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлсэн байна.

3.1.3 Төсөл, арга хэмжээг ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, зураг төсвийн дагуу гүйцэтгүүлсэн ч 1 төсөл, арга хэмжээний зориулалтыг өөрчилж, 1 төсөл, арга хэмжээ төлөвлөлтийн шаардлага хангагдаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.1} дэх хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”, 29^{1.2} дахь хэсэгт “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх” гэж заажээ. Үүнд:

- ❖ 29^{1.2.1} дэх заалтад “тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”
- ❖ 29^{1.2.2} дахь заалтад “барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх”
- ❖ 29^{1.2.3} дахь заалтад “техник эдийн засгийн үндэслэл хийх шаардлагатай төсөл, арга хэмжээнд техник эдийн засгийн үндэслэл, урьдчилсан судалгааг хийлгэсэн байх”
- ❖ 29^{1.2.4} дэх заалтад “урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх”
- ❖ 29^{1.2.5} дахь заалтад “тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх”
- ❖ 29^{1.2.6} дахь заалтад “олон нийтээр хэлэлцүүлсэн байх”

Эрх шилжсэн 7 төсөл, арга хэмжээ нь магадлалын дүгнэлттэй ба үүнээс 2 төсөл, арга хэмжээ нь жишиг магадлалын дүгнэлттэй, 1 төсөл, арга хэмжээг батлагдсан техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлсэн байна.

Хүснэгт 12. Эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний магадлалын дүгнэлт, гүйцэтгэлийн хувь

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Магадлалын дүгнэлт	Гүйцэтгэлийн хувь
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг	2024.10.10 1841/2024	31

XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан	2024.10.10 1840/2024	100
XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	ТЭЗҮ 2025.12.19 2403/2025 Ажлын зураг 2025.10.30 1977/2025	100
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	Жишиг 2024.07.26 1273/2024	65
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	2024.06.07 218/2024	67.1
XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	Жишиг Цамхаг 2024.08.30 1593/2024 Байр 2024.01.22 0091/2024	65
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	2025.04.08 59/2025 2025.06.17 968/2025	100
XII.1.3.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	Техникийн тодорхойлолт 2025.08.21	100

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлд “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага”, 29¹.2.1-т “тухайн төслийн хэрэгжих газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.3 дахь заалтад “техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”, Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх хэсэгт “Эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөл, зургийн даалгавар, норм, нормативын баримт бичиг, стандарт, технологийн даалгавар, тоног төхөөрөмжийн паспорт, техникийн нөхцөл, инженер хайгуулын судалгаанд үндэслэн боловсруулагдсан байх” гэж заасныг зөрчин газрын зөвшөөрөл олгогдоогүй байхад “Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Тус төсөл, арга хэмжээний жишиг магадлалын дүгнэлтэд “... барилгын зураг төслийг батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу байршуулан холболтын зураг төслийг боловсруулж магадлал хийлгэх шаардлагатай...” гэж заасан ч холболтын зураг хийлгэж дахин магадлал хийлгээгүй тендер зарлаж тус ажлыг гүйцэтгүүлсэн байна. Гүйцэтгүүлсний дараа газрын гэрчилгээ гарах боломжгүй болсноос магадлал хийлгэх нөхцөл бүрдээгүй байна. Учир нь Сагил сумын нутагт баригдсан дахин дамжуулах станц нь хилийн зурвас бүхий газарт орсон тул газрын гэрчилгээ гарах боломжгүй болсон байна. Тухайн дахин дамжуулах станц нь баригдаж дуусаад хэвийн ашиглагдаж байгаа боловч улсын комисс ажиллаагүй, гүйцэтгэгч компанид санхүүжилтийг олгоогүй байна.

Иймд дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах талаар Үндэсний аудитын газрын нэгтгэл тайланд тусгуулах санал хүргүүлж байна.

Барилга хот байгуулалтын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 25 дугаар тушаалаар 4,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Инженерийн шугам сүлжээний ажил /Увс Улаангом сум/ төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Увс аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.35-д “инженерийн шугам сүлжээ” гэж ус хангамж, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, газрын тос болон төрөл бүрийн хий дамжуулах хоолой, харилцаа холбооны төвлөрсөн байгууламжийг хэлнэ” гэж заасан байхад тус арга хэмжээний зориулалтыг өөрчилж 300 метр урттай бохир усны шугам татаж төвлөрсөн сүлжээнд холбохоос бусад санхүүжилтийг тохижилтын ажилд зориулалтыг өөрчилж зарцуулсан байна.

Тус төсөл, арга хэмжээний хүрээнд “Увс аймагт ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэлт” нэршилтэйгээр цэнгэлдэх хүрээлэнгийн авто зогсоолын асфальт, бетон хучилт болон Улаангом сумын цэнгэлдэх хүрээлэнг инженерийн шугам сүлжээнд холбох, ногоон байгууламж, тохижилт, засвар, шинэчлэлтийн нэмэлт ажил гэсэн зураг төсөл боловсруулах 2 ажлын даалгаврыг боловсруулж баталсан байна.

Цэнгэлдэх хүрээлэнгийн авто зогсоолын асфальт, бетон хучилтын зураг төсвийг “Засмал зам” ХХК, цэнгэлдэх хүрээлэнг инженерийн шугам сүлжээнд холбох, ногоон байгууламж, тохижилт, засвар, шинэчлэлтийн ажлын зураг төсвийг “Итгэлийн хад” ХХК-аар гүйцэтгүүлж Барилгын хөгжлийн төвөөр магадлалын дүгнэлт гаргуулсан байна.

Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 59/2025 дугаартай магадлалын дүгнэлтээр “Цэнгэлдэх хүрээлэнгийн авто зогсоолын асфальт, бетон хучилт”-ын зураг төсвийг 3,853.5 сая, 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 968/2025 дугаартай магадлалын дүгнэлтээр “ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэлт”-ийн зураг төсвийг 1,037.1 сая төгрөгөөр тус тус хянасан байна.

Төсөл, арга хэмжээний тендерт Мөнхжим өргөө ХХК шалгарч 4,498.9 сая төгрөгийн гэрээ байгуулж ажлыг гүйцэтгэн бохирын шугам, ариун цэврийн байгууламж ногоон байгууламж, гадна тохижилтын ажлыг 2025 оны 07 дугаар сарын 23-ны өдөр, авто зогсоолын асфальт, бетон хучилтын ажлыг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр комисст хүлээлгэн өгсөн байна.

Авто зогсоолын асфальт, бетон хучилтын ажлын хүрээнд 25216 м² авто зогсоол болон явган хүний зам, хашлага, замын чиг сэргээх, тэмдэг тэмдэглэгээ хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. “Ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэлт”-ийн ажлын хүрээнд ногоон байгууламж 26458 м², услалтын систем, 300 метр урттай бохир усны шугам татаж төвлөрсөн сүлжээнд холбох, ариун цэврийн байгууламж, явган хүний зам, сүүдрэвч, сандал, хогийн сав зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.25 дахь заалтад “гадна тохижилтын ажил” гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж

байгуулах үйл ажиллагааг хэлнэ” гэж заасан байна. Дээрх төсөл, арга хэмжээний хүрээнд хийгдсэн 300 метр урттай бохир усны шугам татаж төвлөрсөн сүлжээнд холбох, ариун цэврийн байгууламжаас бусад ажил нь Барилгын тухай хуульд заасан инженерийн шугам сүлжээний ажил биш харин гадна тохижилтын ажилд хамаарч байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 13 дугаар зүйлийн 13.4-т “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.4.1-т “орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “албаны эрх мэдлээ хэтрүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байх тул буруутай албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

Түүнчлэн авто зогсоолын зарим хэсэгт хагарал, цуурал үүссэн байдалтай байна.



Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т “Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна”, 14.6-д “Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна”, Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т “Шинээр барьж байгуулсан авто зам, замын байгууламжийн чанарын баталгаат хугацаа нь гүйцэтгэгч болон техник, технологийн хяналт тавьсан хуулийн этгээдэд тус бүр гурван жил байна” гэж заасны дагуу зохих арга хэмжээг авч ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өглөө.

Мөн Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд “Ерөнхий боловсролын сургуульд цахим танхимын тоног төхөөрөмж” нийлүүлэх тендерт Мобинет ХХК шалгарч гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна. Тус төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтод “Өндөр хурдны интернэтийн 1 жилийн эрх, хурд 20 Mbs-ээс доошгүй байна гэж заасан ч бодит байдал дээр интернэтийн хурд хангалтгүй байна.



Мобинет ХХК-тай байгуулсан гэрээний 1.2-т Монгол улсын иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу техникийн тодорхойлолт, холбогдох стандартын шаардлага хангасан барааг нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх

үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино, гэрээний тусгай нөхцөлийн 10-т “Баталгаат хугацаанд барааны механик эвдрэл гэмтэл, засвар үйлчилгээг нийлүүлэгч тал хариуцна гэж заасны дагуу үүссэн тус асуудлыг гүйцэтгэгчээр шийдвэрлүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өглөө.

3.1.4 Тайлант онд эрх шилжүүлсэн 8 төсөл, арга хэмжээнээс 3 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд эрх шилжин хэрэгжиж буй 8 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээ он дамжин хэрэгжихээр байна.

Хүснэгт 13. Он дамжин хэрэгжихээр төлөвлөсөн 4 төсөл, арга хэмжээ

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Дуусах хугацаа
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг	796.0	246.5	2026
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	3,473.8	2,258.0	2026
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	4,668.7	1,533.5	2026
XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/	900.0	315.0	2026

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Комисс хүлээн авсан 4 төсөл, арга хэмжээнээс "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 16 дугаар хавсралтаар баталсан “Гэрээ дүгнэх маягт”-ын дагуу 3 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэсэн байна.

"Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.3.6-д “Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилт нь гэрээний нийт дүнгийн үлдэгдэл буюу хамгийн багадаа 10 хувиас багагүй байх ба эцсийн санхүүжилтийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын дүгнэлт гарсны дараа олгох бөгөөд дараах баримт бичгийг бүрдүүлж, эх хувь гэсэн баримт бичгийн хувьд цаасаар, бусад баримт бичгийг цахим системээр ирүүлнэ”, 4.3.6.16-д “гэрээ дүгнэсэн акт эх хувь” гэж заасан байна.

“Инженерийн шугам сүлжээний ажил /Увс Улаангом сум/” төсөл, арга хэмжээний хувьд эцсийн буюу бүрэн санхүүжилтээ аваагүй тул комисс ашиглалтад хүлээн авсан ч гэрээг дүгнээгүй байна.

3.2 Барилга байгууламжийн үе шат бүрд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.

3.2.1 Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж, акт фото зургаар баталгаажуулсан байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 35.1.1 дэх заалтад “Нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих”, 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ, 37.1.4 дэх заалтад “Барилгын үе

шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж ажиллах”, 37.1.19-д “барилгын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, фото зургаар баримтжуулан, ил, далд ажлын актыг баталгаажуулах” гэж заажээ.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.4-т “Захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”, 4.4.1.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн шилжүүлсэн эрхийн дагуу захиалагчийн техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай байгуулах” гэж заасан байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан №01/2025 дугаартай гэрээний дагуу хэрэгжүүлэн ажилласан байна.

“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.1-д “Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Эрх шилжин хэрэгжсэн 6 төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу үе шат бүр дээр хэрэгжүүлэн ажилласан байна. Ингэхдээ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг батлагдсан зураг төсөл, захиалагчийн гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу гүйцэтгэж байгаа эсэхэд хяналт тавьж ажлын акт, фото зургаар баталгаажуулж, шаардлагатай зөвлөмж чиглэлийг тухай бүрд нь өгсөн байна.

Аймгийн Засаг даргатай 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан №01/2025 дугаартай гэрээнд тусгагдсан “Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/” төсөл, арга хэмжээний захиалагчийн техникийн хяналтыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар Увс аймгийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-тай 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 03/2024 дугаартай гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна.

Түүнчлэн улсын төсвийн эрх шилжиж ирээгүй 7 төсөл, арга хэмжээнд Барилга хөгжлийн төвийн захирал аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргатай 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн ажилд захиалагчийн техникийн хяналт гүйцэтгүүлэх гэрээ”-г байгуулж захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэгт “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.5 дахь заалтад “Барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах”, 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт “Зураг төсөл зохиогч дараах чиг үүрэгтэй”, 38.1.3 дахь заалтад “Зураг төсөл зохиогч хуулийн этгээд барилга байгууламжийн зураг төслийг хууль тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж баталгаажуулан, хариуцлага хүлээх”, 38.1.4 дэх заалтад “Зохиогчийн техникийн

хяналтыг барилгын ажлын үе шатанд гэрээний үндсэн дээр гүйцэтгэх”, 38.1.8 дахь заалтад “Барилгын ажилд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авахыг захиалагчаас шаардах”, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 178 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм”-ийн 3.1-д “Зураг төсөл зохиогч барилгын ажлын захиалагчтай гэрээ байгуулан барилгын ажилд зохиогчийн хяналт тавина”, 3.3-д “Зохиогчийн хяналт гүйцэтгэх хэлбэрийг зураг төсөл зохиогч, захиалагч, барилгын ажил гүйцэтгэгч тохиролцож гэрээгээр зохицуулна”, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.5-д “Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг”, 4.5.1-т “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 4.5.1.1-т “Төсөл, арга хэмжээний зураг төсвийн зохиогч нь төслийг хэрэгжүүлэхэд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд Барилгын тухай хууль, “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”-д заасны дагуу “Төсөл, арга хэмжээ тус бүрээр захиалагчтай гэрээ байгуулах” гэж заасны дагуу зохиогчийн хяналтыг зураг, төсөв боловсруулсан байгууллага захиалагчтай гэрээ байгуулан гүйцэтгэж байна.

3.2.2 Барилга байгууламжийн бетоны бат бэхэд хяналт хэрэгжүүлсэн байна.

Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Барилга байгууламжид ашиглах барилгын материал, бүтээгдэхүүн дараах шаардлагыг хангасан байна”, 13.1.3-т “чанарыг баталгаажуулсан гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн батламжтай байх”, 40 дүгээр зүйлийн 40.1-т “Барилгын ажил гүйцэтгэгч дараах чиг үүрэгтэй”, 40.1.12-т “барилга байгууламжийн хийц, бүтээцийн даацын бат бэхийг барилгын ажлын үе шат бүрд лабораторийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулан баталгаажуулах” гэж заасны дагуу Зам тээврийн хөгжлийн төвийн Авто замын төв лаборатори болон Увс аймгийн ГХБХБГ-ын лабораториор бетоны бат бөхийн шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулсан байна.

Хүснэгт 14. Бетоны бат бөхийн лабораторийн дүгнэлт

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Бетоны бат бөх лабораторийн дүгнэлт
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг	Увс ГХБХБГ-ын лаборатори 2025.07.03 Увс ГХБХБГ-ын лаборатори 20250140 марк хүрээгүй
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан	Увс ГХБХБГ-ын лаборатори 2025.06.12 20250084
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	Увс ГХБХБГ-ын лаборатори 2025.10.09 20250348
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	Зам тээврийн хөгжлийн төвийн Авто замын төв лабораторийн 2025.07.17 25071144
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	Асфальт 0649/2025 Авто зам тээврийн итгэмжлэгдсэн лаборатори

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Бетоны бат бөхийн лабораторийн дүгнэлт гаргуулах шаардлагатай 4 төсөл, арга хэмжээнд шаардлага хангасан дүгнэлт гарсан байна.

Харин Түгээмэл цамхаг констракшн ХХК-ийн гүйцэтгэж байгаа “Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг” төсөл арга хэмжээний бетоны сорьц шахалтын бат бэхийн шаардлагыг бүрэн хангаагүй байна.

Иймд Барилгын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9-д “барилга байгууламжийн хийц, бүтээц, материал, эдлэхүүнд хөндлөнгийн лабораторийн шинжилгээ хийлгэж баталгаажуулахыг захиалагчаас шаардах” гэж заасны дагуу бетоны бат бэхэд хөндлөнгийн лабораторийн шинжилгээ хийлгэж баталгаажуулах зөвлөмж өглөө.

3.2.3 Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд комисс заавар журмын дагуу хяналт тавьж ашиглалтад хүлээн авсан байна.

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтад “Барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”, 48 дугаар зүйлд “Барилга байгууламж ашиглалтад оруулах”, 48.1 дэх хэсэгт “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна”, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 8.2-т “Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийг үндэслэн 8.1-д заасан хугацаанд багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 8.2.1-д “Барилга байгууламж нь ашиглалтад оруулах шаардлагыг хангасан гэж комиссын бүх гишүүд үзсэн тохиолдолд энэ дүрмийн 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргана” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллаж дүгнэлт гарган барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Хүснэгт 15. Байнгын ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээ

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хүлээн авсан актын огноо дугаар	Гүйцэтгэлийн хувь
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан	2025.09.22 26/2025	100
XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	2025.12.22 №03 20240101015-01	100
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	2025.12.18 40/2025 2025.07.23 14/2025	100
XII.1.3.1	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2025.12.26 №12/01	100

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Мөн Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв болон Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд “Ерөнхий боловсролын сургуульд цахим танхимын тоног төхөөрөмж” нийлүүлэх ажлыг

аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг хүлээн авч акт үйлдсэн байна.

3.2.4 Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг байршуулсан байна.

Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4-т “Барилга байгууламжийн зураг төсөл, байр зүйн дэвсгэр зураг зэрэг мэдээлэл нийтэд нээлттэй, ил тод байна” 37 дугаар зүйлийн 37.1-д “Барилгын ажлын захиалагч дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ”, 37.1.2-т “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10, 8.6.11-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2. хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод, нээлттэй байх 8 дугаар зүйлийн 8.6-д “Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана” гэж заасан байна. Түүнчлэн Монгол Улсын үндэсний стандартад /MNS7023:2023/ заасны дагуу мэдээллийг иж бүрэн нээлттэй байршуулах үүргийг гүйцэтгэгч компани хүлээж байна.

Хүснэгт 16. Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний мэдээллийн самбар байршуулсан байдал

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Мэдээллийн самбар байршуулсан эсэх
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг	тийм
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Цагаанхайрхан	тийм
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/	тийм
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	тийм
XVI.1.1	Бүсүүдийн хөгжлийг дэмжих инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, улс, аймаг, сумдад хэрэгжүүлэхэд шаардагдах Улсын төсвийн хөрөнгө /Бүсүүд/	тийм

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Барилга байгууламж, зам, тохижилтын ажлыг гүйцэтгэж байгаа гүйцэтгэгч компаниуд хууль тогтоомжид заасны дагуу мэдээллийн самбарыг байршуулсан боловч Монгол Улсын үндэсний стандартад /MNS7023:2023/ заасан мэдээллийн самбарт тавигдах шаардлагыг бүрэн хангаагүй байна. Цаашид мэдээллийн самбарын стандартыг хангуулж байхыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт зөвлөлөө.

3.3 Төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнг үнэлж бүртгэсэн ч 1 төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж эхлээгүй байна.

3.3.1 Хэрэгжиж дууссан 4 төсөл, арга хэмжээнээс 1 төсөл, арга хэмжээг зориулалтаар нь ашиглаж эхлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 дахь заалтад “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд эрх шилжин хэрэгжсэн 5,293.6 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 4 төсөл, арга хэмжээг улсын комиссын актаар байнгын ашиглалтад хүлээн авсан байна.

Хүснэгт 17. Эрх шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний хөрөнгийн бүртгэл

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжиж дууссан бол хүлээн авсан актын огноо	Хөрөнгийг бүртгэлд тусгасан байгууллагын нэр	Хөрөнгийг бүртгэлд тусгасан үнийн дүн (сая.төг)
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц1 /Увс Наранбулаг сум/		Аймгийн ЗДТГ	246.5
XV.3.1.1	Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 2 /Увс Цагаанхайрхан сум/	2025.09.22 №26/2025	Аймгийн ЗДТГ	349.8
XI.4.1	Чигжийн голын хөв цөөрмийн зураг төсөв /Увс, Өндөрхангай сум/	2025.12.22 №3	Аймгийн ЗДТГ	145.0
XII.1.1.88	Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/		Аймгийн ЗДТГ	2,258.0
XIV.1.1.54	Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/		Аймгийн ЗДТГ	3,133.5
XVIII.1.2	Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/		Аймгийн ЗДТГ	270.0
XVI.1.1	Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/	2025.12.18 №40/2025	Аймгийн ЗДТГ	1,117.8
XII.1.3.1	Ерөнхий боловсролын сургуульд Цахим танхим-ын тоног төхөөрөмж /Увс аймаг/ худалдан авах	2025.12.26 №12/01	Улаангом сумын ЕБ-ын IV сургууль	149.8

Эх сурвалж: 2025 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ний судалгаа, ажлын баримт

Төрийн өмчийн хорооны шийдвэр гараагүй, харьяа яамнаас хөрөнгийн үнийн жагсаалт ирээгүй зэрэг шалтгаанаар тайлант онд хэрэгжиж дууссан 5,143.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 1,612.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон 3 төсөл, арга хэмжээг комисс байнгын ашиглалтад хүлээн авсан ч олгосон санхүүжилтийн дүнгээр аймгийн Засаг даргын Тамгын газрын бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Мөн “Ерөнхий боловсролын сургуульд Цахим танхим-ын тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаж, зориулалтын дагуу ашиглаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжсэн ч тухайн онд дуусаагүй 9,836.7 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 4 төсөл, арга хэмжээг аймгийн Засаг даргын Тамгын газрын бусад эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна.

Эрх шилжин хэрэгжиж байгаа “Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/” төсөл, арга хэмжээ нь хэрэгжиж дуусах хугацаа болоогүй, хүлээн авсан комиссын акт гараагүй ч хугацаанаасаа өмнө дуусгаж зориулалтын дагуу ашиглаж байна.

Харин тайлант онд хэрэгжиж дууссан “Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 2 /Увс Цагаанхайрхан сум/” төсөл, арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр улсын комисс хүлээн авсан ч ашиглаж эхлээгүй байна.

Дээрх улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр, 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдөр тус тус байгууллагын цахим хуудаст “Түрээслэгчийг сонгон шалгаруулах” зар байршуулсан боловч сонгон шалгаруулалтад оролцогч ороогүй байна. Учир нь тухайн сум, орон нутгийн цахим хуудас болон бусад нээлттэй мэдээлэх сувгийг ашиглаагүй, олон нийтэд мэдээлэл хүргэх ажлыг хангалтгүй зохион байгуулсан байна.

Орон нутгийн өмчийн газраас 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 23 дугаар албан бичгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд “Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах” хүсэлтийг хүргүүлсэн байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/86 дугаар албан бичгээр “Хувьчлах хөрөнгийн материалын бүрдлийг хангаж ирүүлэх тухай” хариу албан бичгийг Орон нутгийн өмчийн газарт хүргүүлсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан “Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга багц 2 /Увс Цагаанхайрхан сум/” төсөл, арга хэмжээг холбогдох баримт материалд үндэслэн шийдвэр гаргаж, ашиглагч талыг тодорхой болгон зориулалтын дагуу ашиглахыг холбогдох албан тушаалтанд зөвлөлөө.

3.3.2 Төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож, бодлогын зорилтын үр дүнд хүрсэн эсэхийг харьцуулан журам заасны дагуу бүрэн тайлагнаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 29^{1.4}-т “Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд хэрэгжүүлнэ”, “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг цахим системд тухай бүр тусгах бөгөөд тухайн байгууллагын мэдээллийн сүлжээнд шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэж санхүүжилт хийгдэх бүрд мэдээллийг шинэчилж байна” гэж заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системд оруулж байна.

Тус журмын 5.4.7-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн тайланг сар бүр энэ журмын 14 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу гаргаж, дараа сарын 5-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ”, 5.4.8-д “Төсвийн

ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан боловч худалдан авах ажиллагаа нь орон нутагт эрх шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар сар бүр энэ журмын 14 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу гаргаж, дараа сарын 05-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ” гэж заасан ч аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 1/13, 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 1/504 дүгээр албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна. Харин бусад саруудад тайланг хүргүүлээгүй байна.

Мөн журмын 5.4.9-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор энэ журмын 20 дугаар хавсралтад заасан маягтын дагуу гаргаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу 2024 оны мэдээг аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 1/210 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн байна. Харин 2025 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг гаргаж хүргүүлээгүй байна.

Цаашид журамд заасан хугацаанд мэдээ, тайланг хүргүүлж байхыг холбогдох албан тушаалтанд зөвлөмж өглөө.

3.3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлж хэрэгжүүлснээр төлөвлөсөн бодлогын зорилтот үр дүнд хүрсэн байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3-т “Засгийн газрын бүрэн эрх”, 9.3.8-д “хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, гүйцэтгэлийг дүгнэх журам болон тайлангийн үлгэрчилсэн загварыг тус тус батлах” гэж заасны дагуу Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг баталсан байна.

Тус журамд заасан арга зүйг удирдлага болгон аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Увс аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж дүнг аймгийн ИТХ-д хүргүүлж хэлэлцүүлсэн байна. Тус тайланд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилт, үр дүнд хүрсэн эсэхийг үнэлсэн байна.

Хүснэгт 18. Улсын төсвийн хөрөнгөөр эрх шилжин хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт

№	Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
			Он	Түвшин				
1	1.1.1.1 Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс. Тэс сум/	Гүйцэтгэл	2024	10	70	70	Тэс сумын 150 ортой цэцэрлэгийн барилгын зураг төслийг “Болор төсөл” ХХК хийж, “Зоос Импекс” ХХК шаардлагатай баримт бичгийн бүрдэл ханган барилга угсралтын ажил эхлүүлэх зөвшөөрлөө авч гүйцэтгэж байна. 1, 2 давхрын цутгалт дууссан, өрлөг, цахилгааны монтаж, салхивчийн ажлууд хийгдсэн.	100

2	6.1.1.1 Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс. Улаангом сум. 8 дугаар баг, Сагил сум. Тариалан сум/	Нэмж суурилуулсан станцын тоо	2024	0	3	3	Юнител" ХХК нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ЦХХХЯ/20240101002 дугаартай гэрээний дагуу "Үүрэн холбооны дахин дамжуулах сүлжээ станц /Увс, Улаангом сум, 8 дугаар баг, Сагил сум, Тариалан сум/"-ийн ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгэн ашиглалтад оруулж туршилт тохируулга, зүгшрүүлэх ажил хийгдэж байна. Тус төсөл арга хэмжээний Сагил сум 2-р баг Бүрхээлтийн орой /Хайрхан уул/ байршил дээр хилийн зурвасын тусгай хамгаалалттай газар тул газар эзэмших эрхийн гэрчилгээ гараагүй гэрээт ажлыг улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна.	100
3	7.1.1.2 Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/	Гүйцэтгэл	2024	10	100	100	Аймгийн Засаг даргын захирамжаар төсөл, арга хэмжээг хоёр багц болгон хуваасан бөгөөд ажлын зураг, төслийг "Чулуутын багш" ХХК боловсруулсан. Төндөрийн сонгон шалгаруулалтыг Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, Багц 1-ийн гүйцэтгэгчээр "Түгээмэл цамхаг констракшн" ХХК, Багц 2-ийн гүйцэтгэгчээр "Цагаан хөшөө трейд" ХХК тус тус шалгарсан. Ажлын явцын тухай мэдээлэл: • Багц 1: Барилгын цутгалт, өрлөг, дээвэр болон цонхны ажил хийгдсэн тухайн онд хийгдэх ажлын гүйцэтгэл 100 хувьтай байна. • Багц 2: Барилга угсралтын ажлыг гүйцэтгэн улсын комисст хүлээлгэн өгсөн.	100
4	8.1.1.5 Улаангом-Тэс хүртэлх хатуу хучилттай авто замын эхлэл /Увс/	Гүйцэтгэл	2024	25	70	70	Төсөл арга хэмжээний зураг төслийг "Засмал зам" ХХК боловсруулсан. Гүйцэтгэгчээр Жол ХХК ажиллаж байна. Тохиромжгүй материалыг хуулж зайлуулах, далан байгуулах, хөлдөлтөөс хамгаалах үе, буталсан чулуун суурийн ажлууд хийгдсэн. Цементээр бэхжүүлсэн суурийн ажил хийгдсэн. Хучилтын ажил хийгдэж байна.	100
5	10.1.1.1 Чигжийн голын хөв цөөрөм /Увс. Өндөрхангай сум/ зураг төсөл боловсруулах	Гүйцэтгэл	2024	20	70	70	Хидро-Инженеринг ХХК гүйцэтгэгчээр шалгарсан. Ажлын зураг төслийг боловсруулж орон нутгаар батлуулсан. Барилгын хөгжлийн төвийн магадлалын дүгнэлтээр батлуулахаар ажиллаж байна.	100

Эх сурвалж: Увс аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн тайлан

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар тогтоолоор аймгийн 2025 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө баталсан байна. Төлөвлөгөө батлагдсаны дараа сайд нарын багцаас шилжиж ирсэн 2 төсөл, арга хэмжээ төлөвлөгөөнд тусгагдаагүй тул үнэлгээнд хамрагдаагүй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11-т "Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх чиг үүрэг", 9.11.1-т "тухайн шатны Засаг даргын өргөн мэдүүлсэн Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан эсэх талаар үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналыг харгалзан тухайн бодлогын баримт бичгийг хэлэлцэн, батлах, эсхүл буцаах" гэж заасны дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, үр дүнг баталгаажуулсан байна.

3.3.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 84.3 хувьтай байна.

Өмнөх оны аудитаар нийт 23 төсөл, арга хэмжээг хамруулан, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр 6 зөвлөмж өгсөн байна. Шалгагдагч байгууллагууд зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг хуулийн хугацаанд боловсруулж, аудитын байгууллагад ирүүлсэн ба өгөгдсөн 5 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 1 зөвлөмжийн биелэлт бүрэн хангагдаагүй байна.

Хүснэгт 19. 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт"-д хийсэн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилтийн хувь
1	Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэн хүлээн авсан 6 төсөл, арга хэмжээг зориулалтын дагуу ашиглах.	100%
2	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтыг мөрдөж ажиллах	100%
3	Гэрээний хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүй 7 төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчээр хийлгэж хүлээн авах.	100%
4	Улаангомын дулааны 2-р станцын зуухны барилгын их засварын ажлыг ашиглалтад оруулах комиссын өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг бүрэн хангуулах	100%
5	Хэрэгжиж дууссан 9 төсөл, арга хэмжээний 2,460.3 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах.	5.5%
6	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Наранбулаг сумын 640 суудалтай сургуулийн барилгыг данс бүртгэлд давхардуулан бүртгэсэн асуудлыг шийдвэрлэх.	100%

Эх сурвалж: Увс аймаг дахь Төрийн аудитын газрын статистик мэдээ

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгагдаагүй 2, зураг төсөвгүй 6, газрын зөвшөөрөлгүй 1 төсөл, арга хэмжээг тусгаж баталсан байна.
2. “Ерөнхий боловсролын сургуульд Цахим танхим”-ын тоног төхөөрөмж-150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний эрхийг хугацаа алдаж шилжүүлснээс худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй байна.
3. Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлд үндэслэн 5,600.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
4. “Инженерийн шугам сүлжээний ажил - Увс Улаангом сум - 4,498.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээний зориулалтыг нь өөрчлөн гүйцэтгүүлсэн байна.
5. “Ерөнхий боловсролын сургуульд цахим танхимын тоног төхөөрөмж” нийлүүлэх тендерийн техникийн тодорхойлолт, гэрээнд заасан хэмжээнд интернэтийн хурд хүрэхгүйгээс хичээл, сургалт хэвийн явагдах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.
6. “Цэнгэлдэх хүрээлэнгийн авто зогсоолын асфальт, бетон хучилтад хагарал, цуурал үүссэнээс ашиглалтын хугацаанд нөлөөлөх эрсдэлтэй байна.
7. Барилга байгууламжийн үе шат бүрд зохиогчийн болон захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлсэн байна.
8. “Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг” төсөл арга хэмжээний бетоны сорьц шахалтын бат бэх стандартын шаардлага хангахгүй байгаагаас шалтгаалж барилгын чанарт нөлөөлж болзошгүй байна.
9. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан мэдээ, тайланг заасан хугацаанд бүрэн хүргүүлээгүй байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
М.БАТСУУРЬ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Увс аймаг дахь төрийн аудитын газрын "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

Тус төслийн 3.1.3-т "Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/" төсөл, арга хэмжээний ажлын санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан гэж үзсэн байна. Тус төсөл, арга хэмжээтэй холбогдуулан Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1/31 тоот албан бичгээр тухайн үеийн Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьт хандан "Увс аймагт ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэл" гэж 4,500,000,000.0 (дөрвөн тэрбум таван зуун сая) төгрөгийн төсөвт өртөгтэй гэж хүргүүлсэн.

Мөн Зам тээврийн хөгжлийн төвийн 59/2025 тоот магадлалын дүгнэлт, зураг төсөл, 2024 оны 53/2024, 3Т-03/2025 тоот зураг төсөл боловсруулах ажлын даалгавар зэрэг баримт бичгүүдэд тус төсөл арга хэмжээ нь "Увс аймагт ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэл" гэж тусгагдсан.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 сарын 24-ны 03/264 тоот албан бичиг, 25 дугаар тушаалд "Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/" гэсэн нэртэй батлагдаж ирсэн тул дээрх тушаалын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зураг төслийн дагуу ажлууд хийгдэж дууссан.

Иймд дээрх ажилтай холбоотой санхүүжилт зориулалт бусаар зарцуулсан дүгнэлт болон хариуцлага тооцох албан шаардлагыг өөрчилж өгнө үү.

Холбогдох материалыг хавсралтаар хүргүүлж байна.



Увс аймгийн засаг даргын тамгын газар
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
Хэлтсийн дарга
Маамуужав Мөнхбаяр
2026-04-24 15:23:03



УВС АЙМГИЙН
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165

Утас: 7045-3262

2026.04.23 № 27

танай _____-ны № _____-т

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Я.ШИЖИРБОЛД



8526430046



УВС АЙМАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

3 дугаар баг, Улаангом, Увс аймаг, 85165
Утас/Факс: 7045-2828
Цахим шуудан: uvs.onug@gmail.com
Цахим хуудас: www.uvs.gov.mn/ onug

2026.04.23 № 71

танай _____ -ны № _____ -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хариу хүргүүлэх тухай

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн 3 дугаар хэсгийн 3.3.4-д өмнөх аудитаар хэрэгжиж дууссан 9 төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгах зөвлөмжийн биелэлт 5,5 хувьтай хэрэгжсэн гэж тайлагнасан байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1.2-д "Батлагдсан эх үүсвэрээр бэлтгэж буй үл хөдлөх хөрөнгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан хэлтэс, нэгжээс хөрөнгө оруулалт, санхүүжилтийн гүйцэтгэл, хөрөнгийн жагсаалт, холбогдох бусад баримтыг аль нэг, эсвэл хэд хэдэн төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх саналын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж бүртгэлд тусгах, эзэмшигчийг тогтоох асуудлыг шийдвэрлүүлнэ" гэж заасны дагуу холбогдох яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэр ирээгүй тул үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй, захиалагчийн хөрөнгө оруулалтын дансанд бүртгэлтэй байна.

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжтэй холбоотой саналгүй байна.

ДАРГА  М.УЛААНХҮҮ

8526070032



УВС АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

Увс аймгийн, Улаангом сум, 7-р баг
Утас: 77456868, Факс: 77456868
Цахим шуудан: uvs@gazar.gov.mn
Цахим хуудас:

2026.04.23 № 195

танай -ны № -т

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас ирүүлсэн "Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлд ямар нэгэн санал байхгүй болно.



Увс аймгийн газрын харилцаа барилга
хот байгуулалтын газар
Захиргаа
Даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч
Баатаржав Бат-Ерөөлт
2026-04-23 16:24:30

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангийн төсөлд:

Аймгийн Засаг дарга 2026 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 6/733 дугаар албан бичгээр “Увс аймаг дахь төрийн аудитын газрын “Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна.

Тус төслийн 3.1.3-т “Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/” төсөл, арга хэмжээний ажлын санхүүжилтийг зориулалтын бусаар зарцуулсан гэж үзсэн байна. Тус төсөл, арга хэмжээтэй холбогдуулан Увс аймгийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1/31 тоот албан бичгээр тухайн үеийн Хот байгуулалт барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурьд хандан “Увс аймагт ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэл” гэж 4,500,000,000.0 (дөрвөн тэрбум таван зуун сая) төгрөгийн төсөвт өртөгтэй гэж хүргүүлсэн.

Мөн Зам тээврийн яамны 59/2025 тоот магадлалын дүгнэлт, зураг төсөл, 2024 оны 53/2024, ЗТ-03/2025 тоот зураг төсөл боловсруулах ажлын даалгавар зэрэг баримт бичгүүдэд тус төсөл арга хэмжээ нь “Увс аймагт ариун цэврийн байгууламж байгуулах, инженерийн шугам сүлжээнд холбох, хөндөгдсөн газрын нөхөн сэргээлт, шинэчлэл” гэж тусгагдсан.

Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны 01 сарын 24-ний 03/264 тоот албан бичиг, 25 дугаар тушаалд “Инженерийн шугам сүлжээний ажил /Увс, Улаангом сум/” гэсэн нэртэй батлагдаж ирсэн тул дээрх тушаалын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зураг төслийн дагуу ажлууд хийгдэж дууссан. Иймд дээрх ажилтай холбоотой санхүүжилт зориулалт бусаар зарцуулсан дүгнэлт болон хариуцлага тооцох албан шаардлагыг өөрчилж өгнө үү” гэсэн санал ирүүлсэн байна.

Ирүүлсэн саналын хүрээнд санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан гэдгийг зориулалтыг нь өөрчилж гэж засвар орууллаа. Харин хариуцлага тооцуулах албан шаардлагыг өөрчлөх боломжгүй гэж үзлээ.

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 195, Худалдан авах ажиллагааны газар 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 27, Орон нутгийн өмчийн газар 2026 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 71 дүгээр албан бичгээр “Улсын төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй байна” гэсэн хариу ирүүлсэн тул тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

1. “Ерөнхий боловсролын сургуульд цахим танхимын тоног төхөөрөмж” нийлүүлэх тендерийн хүрээнд интернэтийн хурдыг техникийн тодорхойлолт, гэрээнд заасан хэмжээнд хүргүүлэх асуудлыг гүйцэтгэгчээр шийдвэрлүүлэх.
2. Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасан мэдээ тайланг хугацаанд нь хүргүүлж байх

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт:

1. “Цэнгэлдэх хүрээлэнгийн авто зогсоолын асфальт бетон хучилтад үүссэн хагарал, цуурлыг гүйцэтгэгч компаниар засуулах.
2. “Аялал жуулчлалын гол чиглэл, улсын чанартай хатуу хучилттай авто зам дагуу үйлчилгээний цогцолборын барилга /Увс/ Наранбулаг” төсөл арга хэмжээний бетоны сорьц шахалтын бат бэхэд хөндлөнгийн лабораторийн шинжилгээ хийлгэж баталгаажуулах

Аудитын дүгнэлтээс дараах саналыг Үндэсний аудитын газарт хүргүүлж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө”-нд тусгагдаагүй 2, зураг төсөвгүй 6, газрын зөвшөөрөлгүй 1 төсөл, арга хэмжээг тусгасан байна. Тухайлбал” 2025 оны төсвийн тухай хуулиар 3,473.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цэцэрлэгийн барилга, 150 ор /Увс, Тэс сум/ магадлалын дүгнэлтээр төсөвт өртөг нь 4,188.9 сая төгрөг болсон байна.
2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах”, 13.1.2-т “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох” гэснийг зөрчин Боловсролын сайдын “Төсөл арга хэмжээний эрх шилжүүлэх тухай” 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн А/411 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн цахим тоног төхөөрөмж /Увс аймаг/” худалдан авах төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн байна.

Цаашид хууль тогтоомжид нийцсэн төсөл, арга хэмжээг төлөвлөн баталж байх, эрх шилжүүлэхдээ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Үндэсний аудитын газрын нэгдсэн тайланд тусгуулахаар санал хүргүүлэв.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР



М.БАТ-АМГАЛАН

Б.АВИРМЭД

Р.АЮУШ
Л.ШАГДАРСҮРЭН